



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/154

Улаанбаатар хот

Үйлчлэх хүрээ батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зүрхний шигдээсийн үеийн судсан дотуурх мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээг хавсралтаар баталсугай.

2. Зүрхний шигдээсийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй, хугацаа алдалгүй үзүүлэх бэлэн байдлыг хангах, үйлчлүүлэгчийн мэдээллийг шуурхай солилцох, батлагдсан стандарт, зааврыг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлэг (Т.Мөнхсайхан), Улсын гуравдугаар төв эмнэлэг (Ц.Төмөр-Очир), аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт тус тус даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 03
дугаар сарын 04 өдрийн 1/15 дугаар
тушаалын хавсралт

**Зүрхний шигдээсийн үеийн судсан дотуурх мэс заслын тусламж, үйлчилгээ
үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээ**

Эрүүл мэндийн байгууллага	Үйлчлэх бүс, нутаг		Тодруулга
	Аймаг	Нийслэлийн дүүрэг	
Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Говьсүмбэр, Дорноговь аймаг, Өмнөговь, Төв аймгийн зарим сум	Багахангай, Налайх, Багануур, Баянзүрх	Тээвэрлэхэд бага хугацаа зарцуулах, ойр эрүүл мэндийн байгууллагад хандах
Улсын гуравдугаар төв эмнэлэг	Ховд, Увс, Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан, Сүхбаатар, Архангай, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон, Булган, Баянхонгор, Дундговь, Өвөрхангай аймаг, Өмнөговь, Төв аймгийн зарим сум	Сүхбаатар, Сонгинхайрхан, Чингэлтэй, Хан- Уул, Баянгол	